



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/165/СТА-ТШЗ

Баянхонг ор хот 2019 он



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576 Цахим хаяг: munkhbat.B@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 70442424, 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Ахлах аудитор: А.Цээням

Утас: 99442140, 88011833 Цахим хаяг: tseenyam.A@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.8.2	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.8.3	Төлбөрийн акт тогтоосон зөрчилтэй асуудал	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
	байхгүй.....	11
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	13
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
3.4	АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	17
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.23 № 2/44

танай _____-ны № _____-т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Г **БАЯНХОНГОР АЙМГИЙН
БУУЦАГААН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ГЭРЛЭЭ ТАНАА** Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн

2019 on gerchilgee_Buutsagaan sumiin Tsetserleg .docx

2519065

бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Д.Гэрлээд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөгөөг тухай бүр нь өгсөн болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.15-наас 2019.02.19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор А.Цээням хариуцаж хэрэгжүүлэв.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдөр 2018.12.18-ны өдрийн 131 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Бууцагаан сумын Цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд заасан Бага насны хүүхдийг өөрийн онцлог чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин, асрах, хамгаалах,

хөгжүүлэх, сургах үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол олгох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тайлант хугацаанд Бууцагаан сумын Цэцэрлэгийн “Хүүхдийг эрүүл байлгаж, тоглох явцдаа өөрөө суралцан, үргэлж баяр баясгаланг авч ирэх, үйлийн эзэн, бүтээгч байх, ая таатай орчныг бүрдүүлж 2018 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж 200 хүүхдийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулсан байна.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Бууцагаан сумын Цэцэрлэг санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүнийг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Бууцагаан сумын Цэцэрлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн тооцоолох программ” хангамж ашигладаг байна.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Бууцагаан сумын Цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 550076,9 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 11001.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

2.8.1 Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал

- Аудитаар барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй хөрөнгийг дахин үнэлж, данс бүртгэлд тусгахдаа санхүүгийн тайланд оны эцэст барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдэл данс 28.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гаргаж буруу илэрхийлсэн байна. Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	908.1	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	908.1	

2.8.2 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудал байхгүй.

2.8.3 Төлбөрийн акт тогтоосон зөрчилтэй асуудал

1. 2018 оны 6 сард 5 ажилтны цалин, амралтын цалингаас даатгуулагчийн төлөх НДШ-ийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон хязгаарлалт хийснээс НДШ-ийн 212216 төгрөгийг дутуу суутгасан, 2. 2018 оны 10-р сарын цалинг бодохдоо гэрээгээр ажиллаж байгаа их эмч Д.Оюунгэрэлд ЗГ-ын 90-р тогтоолын нэмэгдэл 54508 төгрөг, багш А.Номин-Эрдэнэд шийдвэргүйгээр зэргийн нэмэгдэл 60090 төгрөгийг олгосон байна

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "энэ хуулийн 4.2.4 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр НДШ төлнө" гэсэн заалтыг зөрчсөн. Мөн Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн 2018.09.17-ны өдрийн Б/14, Б/15 тоот тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй

2. 2018 оны 8-р сард нягтлан бодогч санхүүгийн программд 9-р сарын орлого 518.3 мянган төгрөгийг орлого авч зарлага гаргасан байхад дээрх материалыг нярав 9-р сард орлого авч зарлагыг гаргасныг нягтлан бодогч давхардуулан бүртгэж мөнгийг Мөнхийн хүч ХХК-д илүү шилжүүлсэн байна. Мөн 2018 оны 12-р сард харилцах данснаас цалинд 63.0 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлагаар тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Бууцагаан сумын Цэцэрлэг чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд тусгай зориулалтын шилжүүлгээр 330547,9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдаж бүрэн авч, оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 1664.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд цалинд зориулан дээд шатны төсөв захирагчаас 1646,8 мянган төгрөгийн санхүүжилт ирснийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Бууцагаан сумын Цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 оны 11 дүгээр сарын 20-д хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит” болон санхүүгийн тайлангийн аудитаар өссөн дүнгээр авч үзэхэд Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож бусад мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн.

Хуулийн 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 26 гүйлгээний мэдээллээс 2 гүйлгээний 14.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Иймд цаашид Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллахыг дарга, нягтлан бодогч нарт тухай бүр нь аудитын явцад зөвлөсөн ба дээрх зөрчил нь нийцлийн аудитын тайлангийн зөрчлийн мэдээнд оруулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/ төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>73,810,969.63</u>	<u>74,884,033.83</u>
33	АВЛАГА	621,245.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	621,245.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	73,189,724.63	74,884,033.83
351	Түүхий эд материал	00.00	164,850.00
35130	Эм боох материал	00.00	164,850.00
354	Хангамжийн материал	73,189,724.63	74,719,183.83
35410	Бичиг хэргийн материал	288,500.00	277,600.00
35420	Аж ахуйн материал	47,170,323.28	47,170,323.28
35430	Сэлбэг хэрэгсэл	585,600.00	585,600.00
35460	Хүнсний материал	4,190,836.80	9,126.00
35470	Бусад хангамжийн материал	20,954,464.55	26,676,534.55
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,315,833,379.55</u>	<u>1,206,508,930.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,315,833,379.55	1,206,508,930.03
392	Биет хөрөнгө	1,315,833,379.55	1,177,108,930.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,547,453,331.00	1,167,458,195.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-246,583,347.04	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,198,184.25	45,017,914.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,904,758.88	-44,316,702.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,059,443.80	16,246,290.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,569,772.58	-10,477,067.50
39217	Ном	3,180,299.00	3,180,299.00
393	Биет бус хөрөнгө	00.00	29,400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	550,000.00	29,950,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,389,644,349.18</u>	<u>1,281,392,963.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>230,048.00</u>	<u>22,600.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	230,048.00	22,600.00
413	Өглөг	230,048.00	22,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,389,414,301.18</u>	<u>1,281,370,363.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,389,414,301.18	1,281,370,363.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	89,476,104.00	118,876,104.00
51101	Өмч: - төрийн	89,476,104.00	118,876,104.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,151,802,882.18	943,997,473.46
51210	Өмнөх үеийн үр дүн	1,151,802,882.18	1,151,802,882.18
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-207,805,408.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	148,135,315.00	218,496,786.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,389,644,349.18</u>	<u>1,281,392,963.86</u>

3.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
СТ-2А

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	339,288,505.00	342,271,519.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	1,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,513,105.00	10,223,619.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	331,775,400.00	330,547,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,646,806.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,646,806.00
1330	Төсвийн захирагчдаас	1,356,465.00	00.00
133003	Хөрөнгийн	1,356,465.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,156,640.00	8,576,813.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,156,640.00	8,576,813.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	365,311,223.84	372,093,223.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	365,311,223.84	372,093,223.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	348,687,950.84	348,905,610.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,507,694.00	194,413,559.00
210101	Үндсэн цалин	194,507,694.00	194,413,559.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,746,806.00	23,726,579.00
210201	Тэтгэврийн даатгал	21,746,806.00	15,959,630.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,941,736.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,553,391.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	388,348.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,883,474.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,534,400.00	29,437,117.00
210301	Гэрэл, цахилгаан	3,071,600.00	2,711,617.00
210302	Түлш, халаалт	22,528,800.00	25,747,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,934,000.00	978,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,567,420.00	3,440,818.00
210401	Бичиг хэрэг	228,700.00	145,630.00
210402	Тээвэр, шатахуун	1,044,410.00	1,002,688.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,923,800.00	1,320,000.00
210404	Ном, хэвлэл	76,000.00	29,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,294,510.00	943,200.00
2105	Нормативт зардал	64,679,892.00	62,939,970.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,800.00	00.00
210502	Хоол, хүнс	64,608,092.00	62,409,970.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	530,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	729,700.00	129,000.00

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	729,700.00	129,000.00
2107	Томилолт, зочны зардал	150,800.00	157,800.00
210702	Дотоод албан томилолт	150,800.00	157,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	467,160.00	637,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	467,160.00	637,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,304,078.84	34,023,616.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,186,140.00	1,218,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	184,000.00	203,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,933,938.84	32,602,216.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,623,273.00	23,187,613.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,608,640.00	21,522,913.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,156,640.00	8,576,813.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,237,000.00	12,477,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,215,000.00	469,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,633.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,633.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,664,700.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,664,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-26,022,718.84	-29,821,704.39
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	177,983,704.33
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,333.61
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	177,982,370.72
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-177,983,704.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-26,022,718.84	-207,805,408.72

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	337,932,040.00	340,771,519.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	337,932,040.00	340,771,519.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	331,775,400.00	330,547,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,646,806.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,646,806.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,156,640.00	8,576,813.00

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,156,640.00	8,576,813.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	337,932,040.00	340,771,519.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	337,932,040.00	340,771,519.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,308,767.00	317,583,906.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,653,847.00	193,769,838.00
210101	Үндсэн цалин	172,500,900.00	173,627,138.00
210102	Нэмэгдэл	8,705,047.00	8,829,700.00
210104	Урамшуулал	14,447,900.00	11,313,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,991,850.00	22,309,697.00
210201	Тэтгэврийн даатгал	20,991,850.00	14,985,414.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,842,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,473,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	713,744.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,294,239.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,534,400.00	29,982,117.00
210301	Гэрэл, цахилгаан	3,005,600.00	3,234,917.00
210302	Түлш, халаалт	22,528,800.00	25,747,200.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,045,470.00	5,137,538.00
210401	Бичиг хэрэг	145,400.00	535,650.00
210402	Тээвэр, шатахуун	1,281,870.00	789,838.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,650,000.00	1,277,100.00
210404	Ном, хэвлэл	80,500.00	96,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	887,700.00	2,438,000.00
2105	Нормативт зардал	68,729,300.00	61,065,160.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,400.00	78,900.00
210502	Хоол, хүнс	62,153,900.00	58,228,260.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,500,000.00	2,758,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,947,700.00	246,750.00
210602	Тавилга	1,700,000.00	00.00
210604	Урсгал засвар	247,700.00	246,750.00
2107	Томилолт, зочны зардал	150,800.00	157,800.00
210702	Дотоод албан томилолт	150,800.00	157,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	566,200.00	583,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	566,200.00	583,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,689,200.00	4,331,806.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,292,300.00	3,999,406.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	396,900.00	332,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,623,273.00	23,187,613.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,608,640.00	21,522,913.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,156,640.00	8,576,813.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,237,000.00	12,477,000.00

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,215,000.00	469,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,633.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,633.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,664,700.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,664,700.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТ-4А

төгрөг

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	89,476,104.00	148,135,315.00	1,151,802,882.18	1,389,414,301.18
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	89,476,104.00	148,135,315.00	1,151,802,882.18	1,389,414,301.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	70,361,471.40	00.00	70,361,471.40
D08	Тайлант үеийн үр дүн	29,400,000.00	00.00	-207,805,408.72	-178,405,408.72
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	943,997,473.46	1,281,370,363.86

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

төгрөг

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	325,190,800.00	325,062,470.00	330,547,900.00	328,883,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	325,190,800.00	325,062,470.00	330,547,900.00	328,883,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	319,277,100.00	319,151,670.00	317,601,800.00	315,937,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,383,200.00	198,383,828.00	194,097,100.00	193,769,838.00
210101	Үндсэн цалин	173,920,700.00	171,683,643.00	173,954,400.00	173,627,138.00

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210102	Нэмэгдэл	8,648,300.00	10,735,369.00	8,829,700.00	8,829,700.00
210104	Урамшуулал	15,814,200.00	15,964,816.00	11,313,000.00	11,313,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,070,000.00	21,975,072.00	22,427,500.00	22,309,697.00
210201	Тэтгэврийн даатгал	14,044,700.00	21,975,072.00	15,057,700.00	14,985,414.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,605,100.00	00.00	1,842,400.00	1,842,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,006,300.00	00.00	1,473,900.00	1,473,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	401,200.00	00.00	368,500.00	713,744.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,012,700.00	00.00	3,685,000.00	3,294,239.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,508,600.00	23,508,250.00	29,982,800.00	29,982,117.00
210301	Гэрэл, цахилгаан	3,005,600.00	3,005,250.00	3,235,600.00	3,234,917.00
210302	Түлш, халаалт	18,000,500.00	18,000,500.00	25,747,200.00	25,747,200.00
210303	Цэвэр, бохир ус	2,502,500.00	2,502,500.00	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,715,500.00	1,714,910.00	5,137,700.00	5,137,538.00
210401	Бичиг хэрэг	192,800.00	192,210.00	547,200.00	535,650.00
210402	Тээвэр, шатахуун	761,700.00	761,700.00	790,000.00	789,838.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	128,200.00	128,200.00	1,278,000.00	1,277,100.00
210404	Ном, хэвлэл	108,400.00	108,400.00	84,500.00	96,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	524,400.00	524,400.00	2,438,000.00	2,438,000.00
2105	Нормативт зардал	69,115,500.00	69,109,210.00	62,271,500.00	61,065,160.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,200.00	88,000.00	78,900.00	78,900.00
210502	Хоол, хүнс	61,874,000.00	61,867,910.00	59,434,600.00	58,228,260.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,153,300.00	7,153,300.00	2,758,000.00	2,758,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	264,700.00	264,700.00	259,200.00	246,750.00
210604	Урсгал засвар	264,700.00	264,700.00	259,200.00	246,750.00
2107	Томилолт, зочны зардал	236,100.00	236,100.00	157,800.00	157,800.00
210702	Дотоод албан томилолт	236,100.00	236,100.00	157,800.00	157,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,723,700.00	1,723,300.00	583,200.00	583,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	715,700.00	715,300.00	583,200.00	583,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,008,000.00	1,008,000.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2259800.00	2236300.00	2685000.00	2685000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	846,400.00	846,400.00	2,352,600.00	2,352,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,413,400.00	1,389,900.00	332,400.00	332,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5913700.00	5910800.00	12946100.00	12946100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,913,700.00	5,910,800.00	12,946,100.00	12,946,100.00

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,710,800.00	5,710,800.00	12,477,000.00	12,477,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	202,900.00	200,000.00	469,100.00	469,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	325,190,800.00	325,190,800.00	330,547,900.00	328,883,200.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	325,190,800.00	325,190,800.00	330,547,900.00	328,883,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	325,190,800.00	325,190,800.00	330,547,900.00	328,883,200.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27	26	27
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	17	18
620003	Үйлчлэх ажилтан	8	8	8	8
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	200	200	202	201
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	200	200	202	201
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27	27	26	27
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	19	19	18	19
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8	8	8